



I-III/2022


Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 15



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өслөө

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2022 оны эхний улиралд 405.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.8 (15.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, улирлаар, тэрбум төгрөг



Энэхүү өсөлтөд утасгүй холбооны үйл ажиллагааны орлого 29.6 (14.1%) тэрбум төгрөг, өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааных 16.3 (42.1%) тэрбум төгрөг, утсан холбооны орлого 4.6 (9.4%) тэрбум төгрөг, цахилгаан холбооны бусад үйл ажиллагааны орлого 3.4 (19.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	2022* I-III
Суурин утасны цэг, мян.шир	308.1	316.7	349.1
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мян.хүн	4 204.2	4 388.3	4 680.1
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид, мянга	905.4	927.7	957.5

Суурин утасны цэгийн тоо 2022 оны эхний улиралд 349.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 32.4 (10.2%) мянган цэгээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Улаанбаатар хотын суурин утасны цэг 30.0 (11.5%) мянгаар өссөн нь нөлөөлсөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид 2022 оны эхний улиралд 957.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 29.8 (3.2%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Кабелийн телевиз хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 8.1 (1.6%) мянга, Орхон аймагт 5.6 (20.9%) мянга, Хөвсгөл аймагт 4.2 (13.9%) мянга, Ховд аймагт 1.8 (10.1%) мянга, Дорноговь аймагт 1.7 (7.7%) мянга, Төв аймагт 1.5 (6.0%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь нөлөөлөв.

Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 2022 оны эхний улиралд 4.7 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 291.8 (6.6%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 334.8 (15.1%) мянга, Дорнод аймагт 1.9 (1.9%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Интернэт хэрэглэгчдийн тоо 2022 оны эхний улиралд 4.2 сая болж, өмнөх оны мөн үеэс 262.7 (6.7%) мянган хэрэглэгчдээр өссөн байна. Энэхүү өсөлтөд үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч 204.7 (5.7%) мянга, гэрээт интернэт хэрэглэгчид 58.0 (18.1%) мянгаар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт шуудан, илгээмжийн хэмжээ 2022 оны эхний улиралд 1.3 сая ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 123.3 (8.5%) мянган ширхгээр буурсан байна. Энэхүү бууралтад дотоодын шуудан, илгээмж 203.4 (14.9%) мянган ширхгээр буурсан нь нөлөөлсөн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2022 оны эхний улиралд 249.2 мянган ширхэг бичиг захидал, 60.5 мянган ширхэг боодол, 115.5 мянган ширхэг илгээлт, 42.8 мянган ширхэг буухиа, 194.4 мянган ширхэг бизнес захидал, 48.0 мянган ширхэг гибрид шуудан, 6.4 мянган ширхэг цахим худалдааны илгээмж, 615.9 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ.

ХҮСНЭГТ 2. ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, төрлөөр, хугацааны эцэст

Шуудан илгээмжийн урсгал	Бүгд		Дотоодын шуудан		Улс хоорондын гарах		Улс хоорондын орох	
	2021 I-III	2022* I-III	2021 I-III	2022* I-III	2021 I-III	2022* I-III	2021 I-III	2022* I-III
	мянган ширхэг							
Нийт шуудан, илгээмж	1 456.0	1 332.7	1 363.4	1 160.0	21.9	29.8	70.7	142.9
Бичиг захидал	187.4	249.2	178.2	215.5	1.8	8.0	7.4	25.7
Боодол	50.9	60.5	34.4	23.0	2.0	3.9	14.5	33.6
Илгээлт	131.4	115.5	93.5	28.3	8.9	13.6	29.0	73.6
Буухиа	56.3	42.8	27.3	28.5	9.2	4.3	19.8	10.0
Бизнес захидал	149.4	194.4	149.4	194.4	-	-	-	-
Гибрид шуудан	39.9	48.0	39.9	48.0	-	-	-	-
Цахим худалдааны илгээмж	7.0	6.4	7.0	6.4	-	-	-	-
Хэвлэл	833.7	615.9	833.7	615.9	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт:

Суурин телефон цэг гэж нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгчийг ойлгоно.

Сансрын холбооны хэрэглэгчид гэж сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.

Интернэтийн байнгын хэрэглэгчид гэж сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернэтийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийг ойлгоно.

Гибрид шуудан гэж хэрэглэгчээс мэдээллийг файл хэлбэрээр хүлээн авч, хэвлэн дугтуйлан битүүмжилж хаягт эзэнд нь хүргэх шуудангийн илгээмж юм.

Боодол гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг ойлгоно.

Илгээлт гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмж юм.



Эх үүсвэр:

ҮСХ, холбооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

Мөнгө, санхүү, үйлчилгээний статистикийн

хэлтсийн статистикч М.Батхишиг

Утас: (976-51)-264797

